



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/104

Алтанбулаг

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "в", 29.1.6 "а", "ж", "л", (30 дугаар зүйлийн 30.1.6, 30.1.17, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.9, 10.4.14, 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.3, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 70 дугаар зүйлийн 70.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 115 дугаар тогтоол, "Журмын хавсралтыг өөрчлөн батлах тухай" 118 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн "Түр журмыг шинэчлэн батлах тухай" 41 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цагаас мөн оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг авч сумд хооронд зорчих хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Д.Амартүвшин)-д даалгасугай.

3.2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хугацаанд 18 градусаас дээш агууламжтай согтууруулах ундааны зүйлсийг худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

4.Төрийн байгууллагуудын 30 хүртэл хувиар ажлын байранд ажиллуулж, халдвар хамгааллын дэглэмийг сахиж, "QR" код байршуулан ажилтан, албан хаагч, үйлчлүүлсэн иргэдийн бүртгэлийг хөтөлж, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулахыг байгууллагын удирдлагуудад үүрэг болгож, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, үйлчилгээний газруудын ариутгал халдваргүйжүүлэлт, халдвар хамгааллын дэглэм сахиж байгаа байдалд

байнгын хяналт тавьж, зөрчил гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, мэргэжил арга зүй, зөвлөгөө дэмжлэгээр ханган тайлан мэдээг нэгтгэн танилцуулж ажиллахыг Байгаль орчин хяналтын улсын байцаагч (С.Мөнхзул)-д даалгасугай.

5. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарн 05-ны өдрийн "Журмын хавсралтыг өөрчлөн батлах тухай" 118 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн "Түр журмыг шинэчлэн батлах тухай" 41, 05 дугаар сарын 07-ны өдрийн "Түр журам батлах тухай" 42, "Түр журам батлах тухай" 43 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Янжиндулам)-д даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Х.Отгонжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



НОТГОНЦОГ